

(Дуулалт жvжиг)



Зохиогч: доктор, профессор Х.Цэдэв

XVII зууны вейн Ойрад Монголын улс төр, нийгмийн нэрт зvтгэлтэн, Монголын тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцэгч, Зvн гарын эзэнт улсын хаан асан Эрдэнэбаатарын Галдангийн вйл хэрэг, амьдрал тэмцлийн тухай зохиолчид уран бvтээлчдийн олон бvтээлvвд бvтээгдсэн байдаг.

□□□□□□□□□□ Төрийн соёрхолт зохиолч Балжирын Догмидын “Үхэл ирвээс вл эмээтvгэй” бэсрэг романыг юуны өмнө нэрлэж болох бөгөөд энэ бvтээл нь уран сайхны шийдэл, дvр зохиомж, тvнчлэн баатруудын дотоод амьдрал, оюун санааны ертөнцийг гарган vзvvлэх гэсэн оролдлогынхоо хувьд өнөө хэр, внэ цэнэтэй гэж vзэж болох бvтээл болсон.

Сvвлийн жилvвдэд тайзны чиглэлийн хэд хэдэн томоохон бvтээлийг зохиолчид туурвисанаас МЗЭ-ийн шагналт нэрт зохиолч Булгудур М.Уянсvхийн “Тэнгэр тайсан вхэл буюу Хар сvлдний оршил”, орчуулагч, зохиолч Наваанзоч Х.Цэдэвийн “Галдан хааны ганцаардал”, МЗЭ-ийн шагналт зохиолч Хидан Н.Сvхдоржийн “Галдан хаан” жvжгvвд

юм. Эдгээр нь бүгд өөр өөрийн гэсэн онцлогтой чамбай бүтээлүүд бөгөөд он цагийн уртад уншигчдын мэргэн оюуны мэлмийгээр шүүгдэх нь магад.

Өдгөө Галдан бошгот хааны 370 жилийн ойн өөр Ховд аймгийн ХДТ-т Н.Сүхдоржийн “Галдан хаан” жүжгийг найруулан тавьж байна. М.Уянсүх, х.Цэдэв нарын бүтээлүүд тайзнаа амилах аз тохиогоогүй ч нэн чухал ач холбогдолтой бүтээлүүд гэдгийг онцлоод, энд бид орчуулагч, зохиолч Наваанзоч Х.Цэдэвийн “Галдан хааны ганцаардал” жүжгийг бүрэн эхээр нь толилуулж байна.□□□□□□

Ойрадын Галдан Бошгот хааны

сүүдэр тохиосны 360 жилийн ойд

зориулвай

ЭХЛЭЛ



/Тайзнаа илд мэс харшилдах, хвлэг морьд янцгаах, хүн орилох зэрэг их тулааны чимээ гарч намжисхийнэ/. Хошиг нээгдэхэд тулаанд эрсэдсэн Ану хатны цогцосыг цэргүүд

авчирч Галдангийн омо тавина. Галдан ухасхийн босч Ану хатны цогцосыг тэврэн сууна.

Галдан хаан:

Ариун хайрын /минь/ бурхан

Ану минь, хатан минь!

Алтан сайхан амиа

Алдчихлаа гэжvv, даанч дээ!

Ану минь ээ, хатан минь ээ!

Ану минь ээ, хатан минь ээ!

Ану минь, чи миний нар байсийм

Амин сэтгэлийн минь гэгээ байсийм

Атаатныг дарахад тулгуур байсийм

Алд биеийн минь тvшиг байсийм

Ану минь ээ, хатан минь ээ!

Ану минь ээ, хатан минь ээ!

Амьдрал тэмцлийн толоо

Асч дүрэлзсэн гал минь бохлоо!

Ариун үйлсийн толоо

Алтан амиа, чи минь, орголоо!

Ану минь ээ, хатан минь ээ!

Ану минь ээ, хатан минь ээ! – гэж дуулаад Ану хатанг оршуулна.
Нилээн тооны цэрэг, ард оршуулгад оролцоно.

Цэрэг эр: Харуулын цэрэг надад

Хаанд оргох айлтгал байна

Чин улсын цэргүүд

Зэрэгцэн нэхсээр айсуй !

Хүрээлж авах янзтай

Холуур тойрсоор айсуй!

Галдан хаан: Тусгаар улсынхаа толоо

Тугаа оргож боссон

Уул усныхаа толоо

Урсах цусаа ч хайрлаагвй

Ард түмэн олондоо

Аминчлан захих сургаал байна

Алс хэтийн амьдралдаа

Андгайлж захих захиас байна

Сонсцгоо, түмэн олон минь

Сонорыг чинь одоо мялаая!

Сүсэглэцгээ, түмэн олон минь

Сүлдэндээ одоо мэхийе!

Миний нутгийн газраас

Бурхан гуйсан ч бvv ог!

Миний нутгийн модноос

Ганцыг гуйсан ч бvv ог!

Алтан шаргал говиос минь

Алгын чинээг нь ч бvv ог!

Ариун тунгалаг уснаас нь

Балгыг гуйсан ч бvv ог!

Ариун эрдэнэт хорсноос нь

Чимхийг ч гэсэн бvv ог!

Арвин түмэн сүргээс нь

Ончин ишиг ч бvv ог!

Омнод хоршийнхоо дотрыг

Онгийж сайтар харж бай!

Онод мандах Монголоо

Ороороо хамгаалахад бэлэн бай!

Олон ард: Хурай Хурай Хурай хашгирна

Галдан: Үнэнч цэргүүд минь сонсоцгоо!

Үхэх сэхэхээ үзэцгээе!

Ану хатныхаа ошоог авч,

Амраая, түр ч болов сэтгэлээ!

Цэргүүдийн хор: Хүйтэн жадны үзүүрт алтан амиа огцгоое!

Хүсэл бодол бүхнээ эх орондоо оргоцгоое!

Хорсол атаа, хоосон магтаалаас салцгаая!

Хуурамч зан, урван тэрслэхээс ангижирцгаая!

Баатар эрс, дайсан хичнээн олон ч

Барааг нь хараад эргэж зугтахгүй!

Бачит дайсны арга мэх нарийн ч

Баатар жанжнуудаас минь давахгвй!

Хвчит томор цайтлаа улайдсан ч

Хвнийг хэзээ ч айлгаж чадахгвй!

Бид үнэнч цэрэг хэвээр үлдэцгээнэ!

Бид дандаа шударга хэвээр үлдэцгээнэ!

/Тайзны захаар Чин улсын цэргүүдийн бараа харагдан их тулааны чимээ нижигнэсээр хошиг хаагдана/

ЗОВШИЛ ХЭМЭЭХ НЭГДУГААР ҮЗЭГДЭЛ

Галдан хааны гэр оргоо. Хойморт Галдан цагаан эсгий олбогон дээр заларна. Дэргэд нь Данжила, Равдан хоёр болон сайд, баатар эр нарын хүмүүс эгнэн суужээ. Туульч овгон ойрадын нэгэн туулийг уянгалуулан хайлж суух авай. Оргоонд арваад хүмүүн байна. Аягачин идээ будаа барин, айраг цагаа аягалан зочдод барина.

Туульч: /Жангар туулийн хэсгээс хайлна/

Галдан хаан: Арван гурван оргилтой

Алтай эх орон минь хаа байна!

Хорин гурван оргилтой

Хангай эх орон минь хаа байна!

Онгийн гол руу дохох үү?

Ордос нутгийг дээрэмдэх үү?

Манжийн агуулахыг тонох уу?

Хами тийшээ звглэх үү?

Агт морьд, эр цэргээ сэлбэж

Алтай нутгаа бараадах уу?

Урвагч хаадыг буцах аваас

Уулгалан дарж нухчих уу?

Хаашаа явж юу хийх вэ?

Хамтарч цомоороо ярьцгаая!

Данжила: Бошгот хаан минь, болгоо!

Бидэнд хvн хvчин алгаа!

Онгийн гол руу дохox

Унаа хосог ч алгаа!

Ордос нутгийг дээрэмдэх

Бололцоо даанч алгаа!

Аль байгаа бvхнээ дайчилж

Алтай нутгаа зорьцгооё!

Үхэр Цэвээн-Равдантай

Үхэх сэхэхээ үзэцгээе!

Равдан: Алтай тийшээ зүглэвээс

Ард олон Цэвээн-Равдан руу зугатна!

Арван гурван оргилт Алтай,

Буурь нутаг минь эзгвйрнэ!

Энэ л уулын бэлээс

Эх нутаг минь эхлэж байгаа!

Энэ л голын хондийгоос

Эх орон минь эхлэж байгаа!

Манжийн цэрэг энд

Мадаггвй ирж чадахгвй!

Хэрвээ ирэх аваас

Хэсэглэн дарж сонооно!

Хойш эргэж Буриадыг дээрэмдэн

Хоол хvнсээ базаавал яана!

Хами-г Цэвээн-Равдан эзэгнэсэн!

Харагдсан зvгтээ явж болохгvй ээ!

Цагаан Шидэр-Хашка:

Муугаа vзэж явснаас

Манжид дагаар орцгооё!

Их эзэн Кан-Си-г бараадвал

Идэх уухаар дутахгvй!

Yйлээ vзэж зовсноос

Омнод хоршоо бараадъя!

Олсох цангахыг мартаж

Оег тансаг амьдарцгаая!

Галдан хаан /ихэд уурсан/:

Манжийн хааны шавхруу горьдож

Мал шиг амьд явснаас

Эх орноо сахин хамгаалж

Эр цэрэг шиг тэмцэх минь дээр!

Эх орноо умартсан

Эргvv энэ амьтныг

Олон түмний нүдэн дээр

Одоохон цаазаар авсугай!

- гэхэд Равдан, Данжила тэргүүтэн Цагаан Шидэр Хашка-г цаазлахаар авч гарна.
Галдангийн бие чичирч, уур омгоо арайхийн дарна. Тэд тодолгвй эргэж орж ирнэ.
Зовшилдоон ийн

үргэлжлэнэ.

Үржинжав: Ан гороо ховордож

Арга тасархад хүрлээ!

Хаврын дунд сард л

Ногоо цухуйдаг болжээ!

Тор улс чинь уналаа!

Түмэн олон чинь бутарлаа!

Эцэг эх, үр хүүхдүүд

Эхнэр нохор салан хагацлаа!

Муу нүхэдсэн тарвага шиг

Амиа алдахад хврилээ!

Хүсэл зоригийг чинь дагасаар

Хоорхийс болж хувирлаа!

Энэ бүхний лай ланчиг

Эзэн чамайг л дайраасай!

Ай хоорхий, чи тамд очоорой!

Араас чинь бид ч бас очноо!

Галдан хаан /уурлаж буй авч биеэ барьж байгаа нь илт/:

Үржинжав, чи сонс!

Үнэнийг чи хэллээ!

Гашуун ч гэсэн үнэн үг

Гайхам сайхан сонсдоно!

Урван тэрслэхээс ч илүү

Урам зориг нэмлээ!

Үнэн үгс хэллээ гэж

Ош хонзон санахгүй!

Эзэрхэг манжийг дагаж

Элэг доог болохгүй!

Эх сайхан нутгаа

Эгнэгт сахиж үлдэнэ!

Гаднаас Бадма Мыш /Зүүнгарын хаант улсын элч Москвагаас буцаж ирсэн/ орж ирнэ.
Бадма Мыш:

Амгалан байна уу, хаантан?

Амар байна уу, олон түмээн?

Алд бие минь ноходтэйгээ

Алтан Москва хүрээд ирлээ.

Хаан таныхаа илгээлтийг

Хаанд нь бариад ирлээ.

Галдан: Аян замын уртад

Алжааж ядарч ирэв үү?

Алс хойд нутгаар

Амар жимэр байна уу?

Алексей хаан юу айлдсаныг

Алив, бушуухан ярь!

Ямар сонинтой ирснийг тань

Яриулж сонсмоор байна!

Бадма Мыш: Алексей хааны илгээлтийг

Анир тавьж сонсоно уу?

Хачир чимэг нэмэлгвйгээр

Хаан танаа айлтгая:

“Зүүнгарын хаан танаа

Амар амгаланг айлтгая!

Элч толоологчоо явуулсанд

Эрхэм Галдан танаа талархая!

Үнэтэй бэлэг илгээсэнд

Үнэнхvv сэтгэлээс гялайлаа.

Аринц, тувагийн иргэдээс

Алба гувчуур шаарджээ чи!

Эс зовшоорох аваас

Зэвсэглэн ходлоно гэжээ чи!

Энэхvv шаардлагыг би

Эс хвлээн авлаа.

Зэр зэвсэг хангинуулж

Цэрэглэх хэрэг байна уу даа?

Ам хэлээ ойлголцож

Амар сууцгаавал ямар вэ?

Эв эеийг эрхэмлэж

Энх жаргацгаавал ямар вэ?

Хаан та элч толоологчоо

Хэзээ ч илгээсэн болно.

Москва хүрэх замыг

Манайхан газарчлах болно.

Энэ талаар Сибирийн захирагчдад

Зарлиг гаргаж элч томилов.

Оросын хаан Алексей Михайлович,

Москва. 1673 оны 11 сарын 10”

Бадма Мыш /амсхийснээ/:

Алтан хуйтай сэлэм,

Амтат дарс тэргүүтэй

Алексей хааны бэлгийг

Гардан хвлээж авна уу?

Галдан хаан бэлгийг хвлээж авна. Сэлмийг ихэд таашааж байгаа бололтой, хуйнаас нь гаргаж үзэнгээ: Орос дарханы хийсэн

Онцгой сайн сэлэм байна.

Олиггвй дайсныг дарахад

Онц хэрэгтэй сэлэм байна.

гэж дуулаад сэлмийг хуйнд нь хийнэ.

Галдан хаан: Алексей хааны илгээлтийг

Анхаарал тавьж сонслоо.

Аринц, Тувагийн ард олноос

Алба гувчуур огохгвй гэжээ.

Цэрэглэн ходлоно гэдгийг

Цэглэвэл зохино гэжээ

Эв эеийг сахиж

Энх амьдрахыг хвсчээ.

Баатар эр: Алексей хааны илгээлтийг

Алга хавсран дагах уу?

Аль эсвэл сорголдож

Азаа туршин дайтах уу?

Оросын омнод нутаг руу

Уулгалан дайрвал яасийм?

Олз омгоо арвижуулж

Олныгоо цатгавал яасийм?

Сайд: Омнод хоршийн байдал

Оор болсон вед

Чин улсын байдал

Цэвүүн болсон цагт

Оросын хааны саналыг

Ойшоож үзвэл зохистой!

Огоорч үүнийг мартваас

Идэш болох аюултай!

Галдан хаан: Байдал ээдрээтэй вед

Бодолцох зүйл байнаа!

Дотоод гадаад байдлаа

Тунгааж үзэхүл зохиноо!

Яаран Орос руу дайрваас

Яйран сүйрвэл яахийм!

Чин гүрний цэргүүд

Цэрэглэн дайрвал яахийм!

Сайдын үгийг дагах нь

Сарны гэрэл шиг ачтай!

Их Орос хорштэй

Эвийг сахих нь зүйтэй!

Сайд /хаанд хандан/: Ухаалаг шийдвэр гаргасанд

Урамтай байна, дэмжиж байна.

Урд хоршийнхоо бодлогыг

Ухаж тунгаах нь зvйтэй байна.

Холч шийдвэр гаргасанд

Хоортэй байна, хохvлж байна.

Хуур юугаа татаж,

Тууль юугаа сонсоцгооё!

Экэл хогжмийнхоо аялгуунд

Бийгээ биелэж наадацгаая!

Их хааныхаа зарлигийг

Инээд хоороор угтацгаая!

/Хогжмийн ая эгшиглэж, бийчид биелэнэ. Овгон туульч хуурдан vргэлжлvлэн хайлна, vггээр vзэгдэл ондорлоно

ТЭРСЛЭЛ ХЭМЭЭХ ХОЁРДУГААР ДУГААР ҮЗЭГДЭЛ

Кан-Си хааны хээрийн оргоо. Кан-Си хаан суудалдаа заларсан харагдана. 2-3

сайд хамт байна. Галдангаас зугатан ирсэн Дамба-Хашка-г хоёр түшмэл олноо түлхэн орж ирвүт овдог сохорцгоон моргов. Дамба-Хашка ч гурвантаа сунан моргоод босно.

Дамба-Хашка: Их эзэн хаантан, та

Ивээлдээ багтааж авна уу?

Таныг бараадахаар ирлээ.

Таалалдаа багтааж соёрхоно уу?

Кан-Си: Бусдын газар нутгийг

Булаан авч эзлэдэг

Бусармаг энэ явдал

Галдан хааны зан уу?

Ахан дүүсээ хороодог

Алан хядахыг эрхэмлэдэг

Галзуу догшин явдал

Галдан хааны зан уу?

Дамба-Хашка: Тийм бишээ, эзэнтэн минь

Тэр чинь, их сайн хvн!

Тvмнийхээ толоо зvтгэсэн

Торолхийн жанжин хvн!

Кан-Си: Чин гvрэнд зvтгэхээр

Чин санаатай ирсэн бол

Тэрслvв Галдангийн талаар

Тодорхой айлтгал мэдvл!

Хаагуур нутаглаж байгааг нь

Хааж нуулгvй айлтга!

Хэдвй хир хвчтэйг нь

Хамаг үнэнээр нь айлтга!

Эс тэгвээс чамайг

Ивээлдээ багтаах аргагвй!

Эмнэг морины сүүлнээс уяж

Ирсэн зүгрүү чинь буцаана даа

Дамба-Хашка: Огоомор эзэн хаан минь

Үнэн моноор нь айлтгая!

Очүүхэн боол би бээр

Үнэнийг зовхон айлтгая!

Хэрлэн, Туулын хондийгоор

Хээрийн оргоотэй яваа!

Хүн хвч гээд байх юм

Хуруу дарамхан үлдсэн!

Халх нутагт гантай

Хур бороо ч дусахгүй

Мал сүрэг нь ч таргагүй

Маш хэцүү болсоон!

Кан-Си:

Улаан будангийн тулаанаас

Ум хумгүй зугадсан уу?

Муур харсан хулгана шиг

Нүүр буруулан зайлсан уу?

Аргагвй ялагдах болохоор

Аврал хайн зугадсан уу?

Ачаа хосгоо ч орхиод

Амь тавин зайлсан уу?

Дамба-Хашка:

Амаргвй байдалд орох вед

Аргаа олох нь буруу гэжvv?

Армиа авч vлддэг нь

Арга ухаан биш гэжvv?

Хохирол багатай дээр нь

Хvмvvcээ аварч чадсан

Галдан хааныхаа зонг

Гайхан магталгвй яах вэ?

Кан-Си:

Илvv дутууг орхилгвй

Үнэнийг очих шиг боллоо!

Шулуун товч vгтэй

Шударга дайчин шиг байна!

Манжийн цэрэгт алба хаа!

Манай туршуулаар буц!

Галдан чамайг сэжиглэхгвй!

Ганц ч болов хvн хэрэгтэй!

Галдангийн итгэлийг олж

Хэрхэх эсэхийг нь танд!

Оргон зайлах аваас

Олзлож авахыг бод!

Галдангийн толгойг авчирвал

Түмэн лангаар шагнана.

Эрх ямбаар ч дутаахгүй

Элбэг хангалуун жаргаана!

Дамба-Хашка: Очvvхэн би бээр зарлигийг дагая!

Оноодроос эхлэн манжид зvтгэе!

Их эзэн хаан танд гялайлаа!

Ивээлдээ авсан тань талархлаа! –

гээд моргон гарахад 2 түшмэл дагалдана

Кан-Си: Галдангийн цэргийг дотроос нь

Тос отох шиг болгоё л доо!

Оорийнх нь хүмүүсийг оорт нь

Остон болгоод үзье л дээ!

Унаа мал нь тарга тэвээрэггүй

Утаа манасхийх их буугүй

Арга нь тасраад зүдрэхийн цагт

Аврал гуйгаад ирэх нь лав!

Манжийн эзэн хаан надад

Моргож согдоод ирэх нь лав!

Тэрслvv Галдан чамайг даа!

Тэр цагт яахаа би мэднээ! – хэмээн дуулж, хvйтнээр хохрох авай.

Гаднаас нэгэн тvшмэл орж ирээд ийн айлтгана.

Тvшмэл: Галдангийн хvv Сэвдэнбалжирыг

Гартаа оруулж авчирлаа!

Анд явж байх цагаар нь

Аргандаа оруулж баривчиллаа!

Кан-Си: Ямар сайхан мэдээ вэ!

Яасан сайхан хэрэг вэ!

Галданг буулгаж авахад

Гавъяаг чи байгууллаа!

Хэргэм зэргийг чинь нэмье!

Харъяат албатыг чинь нэмье!

Ямар сайхан мэдээ вэ!

Яасан сайхан хэрэг вэ!

Галдангийн удмыг устгах

Гайхалтай боломж гарлаа!

Чин улсын сүр хвчийг

Чинад мандуулах цаг боллоо! – хэмээн дуулж Галдангийн хvv Сэвдэнбалжирыг барьж ирсэн сургийг дуулаад Кан-Си ихэд баярлан хоорсон байдалтай болох аж. Гаднаас Галдангийн хvv Сэвдэнбалжирыг тvlхэж гулдарсаар хэдэн хvн орж ирнэ.

Кан-Си Сэвдэнбалжирт хандан:

Ган гачигт нэрвэгдсэн

Ганцаардлын туйлд орсон

Хаан эцэг Галдан чинь

Хэзээ ирж дагаар орох вэ?

Сэвдэнбалжир:

Эцэг минь юу бодож явааг

Эгээ би яахан мэднэм!

Эр хvний санаа бодолд

Эмээлтэй морь багтдаг бус уу!

Эх орноо тэнд орхиод

Эзэн хаан таныг тvшнэ гэжvv?

Энэ жил хэдий гантай ч

Эргэх улирал оорчлогдоно!

Кан-Си:

Алтайн давааг давах

Амархан замыг зааж ог!

Их цэрэг Алтайг давах

Эвтэйхэн замыг зааж ог!

Эс тэгвээс чамайг

Элдвээр тамлах болно!

Эргээд буцах аргагвй

Эргvv мал болгоно!

Сэвдэнбалжир:

Тамлал зовлонгоос эмээж

Таныг хуурч чадахгвй нь!

Эргvv мал болохоос айж

Эзэнтэн таныг мэхэлшгvй нь!

Аагим халуун, улаан ган

Алтайг давахад саад болно!

Ээрэм говийг гатлан туулж

Их цэрэг явах аргагvй ээ!

Кан-Си:

Алтайг давах аргагvй гэнээ!

Арай чи мэхлээгvй биздээ!

Чи хэдий миний дайсны хvv ч

Чин vнэнийг очсон болохоор

Энэ удаа чамайг цаазалшгвй!

Эзэн хааны шоронд сууж бай!

Хэлсэн уг чинь үнэн болохыг

Хэрэг явдал харуулаад огноо!

Кан-Си: Галдангийн хvvг аваад яв!

Гар холийг нь гавлан цагд!

Хэрвээ энэ хvvг алдчихваас

Хэрхэвч та нарыг оршоохгвй!

Тvшмэлvvд Кан-Си-д хэдэнтээ согдон Сэвдэнбалжирыг урдаа оруулан тvлхсээр авч гарна.Хаан нэгэн ойр дотнын тvшмэлтэйгээ Сэвдэнбалжирийг хэрхэх талаар бодлого боловсруулж сууцгаана.

Кан-Си: Сэвдэнбалжирийг хэрхэх талаар

Сэжиг таавар ямар байна?

Огоомор эзэн хааны ивээлд

Онод багтаавал ямар вэ?

Түшмэл: Остон Галдангийн хүүг

Оноодор цаазаар авъя

Оргон олны нүдэн дээр

Толгойг нь тас цавчъя

Манж гүрний эсрэг

Зэвсэг агссан Галдангийн

Мах цусны тасархайг нь

Нэгмосон таславал ямар вэ?

Кан-Си: Яарах хэрэггүй, түшмэл минь

Сайтар тунгаах хэрэгтэй

Давхар давхар мэх гаргаж

Дагаар орогсдыг хуурах хэрэгтэй

Огоомор сэтгэл гаргаж

Ивээлдээ авсан дүр эсгэ!

Туслагч Чиндайн охинтой

Гэрлүүлсэн зар тараа!

Эзэмшил нутаг зааж

Энэрэлдээ авсан дүр эсгэ!

Хоронго мал тасдан огч

Хайрлаж энэрсэн торх гарга!

Дагаар орогсдыг оршооно гэж

Зар сайн тараа!

Манжийн хааны ивээлд багтаж

Ашид жаргах мэт санаа торvvл!

Чингэж хэрэв чадваас

Чин гvрэн бvх дайснаа

Оршоол хэмээх мэхээр

Оорийн гартаа оруулна!

Тvшмэл: Жа, мэдлээ эзэн хаан минь

Таны vг бол тушаал билээ

Остнийг гартаа оруулдаг

Оргон ухааныг чинь биширмv

Огоомор эзэн хаантан минь

Олмийд чинь мэхийн моргомв

Кан-Си: Сэвдэнбалжирийг хороох гэсэн

Сэтгэлээ түр хорьж бай

Зүүнгарыг эзлэн авмагц

Зүйл дуусгах нь гарцаагүй

Галдангийн удмыг үндсээр нь

Сэхэхгүй болтол нь тасланаа

Хойд зүгтээ дайсангүй

Амар амгалан жарганаа

Хошиг хаана

АВЛАЛ ХЭМЭЭХ ГУРАВДУГААР ҮЗЭГ ДЭЛ

Хээр газар. Галдан шадар хvmvvстэйгээ цагаан эсгий олбог дэвсэн сууцгаана. Тогооч нар задгай гал дээр саяхан авласан зээрийн махыг чанана.

Жанжин /Галданд хандан/:

Ангийн тэнгэр хийморьтой байна!

Арваад зээр намналаа шvv

Тарган зээрийн хорхог ч

Тансаг хоолны нэг дээ!

Галдан: Ангийн хийморио сэргээж

Авд мордоод ирлээ!

Бурхан тэнгэрээс бидэнд

Буян хишгээ хайрлалаа!

Эр хvний жаргалын дээд

Эзгvй хээр гэдэгсэн билvv!

Эрхэндээс ирvvлсэн дарсыг

Эрхэм тvшмэлvvдэд согно!

Нэгэн тvшмэл дарс аягалан Галдангаас эхлэн тойруулан согнох аж. Хоор хогжоон эхлэнэ. Хэн нэгэн ойрад уртын дуу дуулж, зарим нь тvрж байна /Дууг сонгох/. Энэ vеэр алсад морин товоргоон сонсогдоно. Хvмvvс гайхан тэр зvг ширтэцгээнэ.

Тvшмэл: Тэртээ уулын цаагуур

Тоос татаад байх чинь!

Асга хад нурав уу?

Адуу мал давхилдав уу?

Жанжин: Шарга морьтой хvмvvн

Шавдуулан давхисаар айсуй!

Шороо тоос манаргасаар

Шуудхан чиглээд айсуй!

Элч /Галдан хааны омоно согдон/:

Их эзэн хаантан минь!

Оршоо, намайгаа оршоо!

Очvvхэн муу боол чинь

Оодгvй мэдээ авчирлаа!

Муу мэдээтэй ирлээ гэж

Намайгаа битгий цаазал!

Эзэн хаан тандаа

Эгнэгт vнэнчээр зvтгэнэ!

Галдан хаан: Ямар хэрэг гарсийм бэ?

Ягштал үнэнээр нь ярь!

Чамайг би оршооноо!

Чин үнэнийг л огвул!

Элч: Чиний ач Цэвээн-Равдан

Нутаг орныг чинь булаалаа!

Хайртай нэгэн хатан чинь

Хэл дуулгахаар явууллаа!

Галдан ухасхийн босч сэлмээ сугалснаа буцааж хийнэ. Ихэд уурссан харагдана.

Галдан хаан: Оодгвй муу новшийг дээ!

Оорийн гараар тарчилгаж

Эр хонины тойгыг

Эргvv толгой руу нь чихье ээ!

Бушуул, цааш нь яриач!

Болсон явдлыг тоочооч!

Уур омог минь буцалж

Ухаан санаа самуурч байна!

Элч: Оодгвй муу Цэвээн-Равдан

Оорийгоо хаанд оргомжлов!

Хами, Хотгойдыг эзлэж

Хангайн даваануудыг хаалаа!

Танд үнэнч хатан тань

Дараах үгийг дайлаа:

“Эр нохор Галдан минь

Эргэж наддаа ирээч дээ!

Омог тоголдор бүргэд минь

Үтэр түргэн ирээч дээ!

Олзлогдсон намайгаа чолоолж

Оногдсон жаргалаа эдэлцгээе!”

Галдан хаан ухасхийн босоход Эрхэндээс ирүүлсэн улаан дарс цагаан эсгий дээгүүр урсан шингэв.

Галдан хаан: Оорийн газар нутгаа ч

Ондор уулс даваагаа ч

Оргон цээл гол морноо ч

Огоомор олон түмнээ ч

Оноодрийг хүртэл би

Оштон дайсанд алдаагүй билээ!

Оодгвй муусайн дайснуудын

Овдгийг чичрүүлж явсаан би!

Хаан торийг минь булаасан

Хорон санаат чамайг уу!

Оорийнхоо гараар цаазлаж

Ос хонзонгоо авна даа! – гээд хараал зүхэл тавин замдаа
дайралдсан аяга тавгыг ошигчин хээрийн оргооноос гарна

АРСАЛДАЛ ХЭМЭЭХ ДОРОВДҮГЭЭР ҮЗЭГДЭЛ

Тайзнаа Галдангийн цэргүүд, Кан-Си-гийн цэргүүд 2 талаас эгнэн жагссан байх ба омо нь Галдан, Кан-Си нар байлдааны хуяг дуулгатай зогсоно. Цэргүүдийн олонх хэсгийг тайзны арын зураг дээр алслалтаар дүрслэн харуулна.

Галдан хаан:

Далай Чин улсад

Дагаар орсон Түшээт хааныг

Эрдэнэ зуугаа орхиод

Эгнэгт урвасан Хутагтыг

Хамаг албатаа малтай нь

Хамж туусан ноёдыг

Халх Монголоо орхиод

Хятадад урвасан хаадыг

Би хэзээ ч оршоохгвй

Бичиг оргож согдохгвй

Халхтай би байлдаагвй

Хамаг Монголтой дайтаагвй

Хутагт, Твшээт хаан хоёрыг

Хурдан эргүүлж ог!

Хувийн тооцоо надад байна

Хойшдын заяа нь тод байна

Кан-си:

Ойрдын хаан Галдан чи

Одоохон наашаа нvv!

Олны тусын толоо

Онцлож хийх яриатай!

Огоомор эзэн хаандаа

Оглог барьцаа орго!

Онийн энхийг сахиж

Есон цагаанаа орго!

Остон хоёр хvнийг чинь

Эргvлж чамд огохгvй!

Энхийн хэлэлцээр хийвээс

Энvvн шиг буян байхгvй!

Галдан хаан:

Онцолж ярих хэлцээнд чинь

Огтоос би очихгvй ээ!

Ойрад Монгол хэзээ ч

Од шиг гялалзах хувьтай

Оглог барьц авна гэж

Их санавал гонжийнжоо!

Есон цагаан авна гэж

Ероол хvсвэл гонжийнжоо!

Остон хоёр хvнийг минь

Огох эсэхээ шийдээрэй

Энхийн хэлэлцээр хийхгvй!

Энvvн шиг vнэн байхгvй!

Кан-си:

Хvчит цэргээ ходолгож

Хvйс тэмтрэнэ чамайг

Хоорхий Галдан чамайг

Хосрий яс болгоно

Арван тvмэн цэргийг минь

Аргална гэж санана уу, чи!

Арчаагвй муу Галдан чи

Аврал гуйсан чинь дээргвй юв!

Хорин түмэн цэргийг минь

Хоргооно гэж санана уу, чи!

Хоорхий муу Галдан чи

Холд минь согдох нь дээргвй юв!

Галдан хаан:

Хвйс тэмтрэнэ хэмээн

Хвчээр бvv сүрдvvл!

Хосрий яс болсон ч

Хох Монголдоо л үлдэнэ!

Арван түмэн цэргээс чинь

Айнаа л гэж гонжийнжоо!

Аргалж байгаад дийлнэ!

Арсалдаж байгаад дуусна!

Хорин түмэн цэргээс чинь

Хулчийна гэж гонжийнжоо!

Хүчээ үзээд дуусна!

Хосор унатлаа үзэлцэнэ!

Кан-си:

Дагаар орохыг чинь харж

Сэтгэлээ нэг хангана би!

Давхар мэхэндээ оруулж

Бахаа нэг хангана би!

Зорvуд Галдан чамайг

Зоосны нvхээр гvйлгэнэ

Зогноод хэзээ ч хvршгvй

Зовлонд чамайг унагана

Энхийн хэлэлцээр хийж

Эргээд уулзсан ч болно!

Эзэн хааны элбэрэлд

Эгнэгт багтсан ч болно!

Галдан хаан:

Оолдийн Галдан хэзээ ч

Омнод гүрнийг дагахгүй

Хаан Галдан хэзээ ч

Хятад гүрнийг түшихгүй

Зоосны нүхээр орсон ч

Зовлого минь барагдахгүй

Зовлонд би унасан ч

Зорилгодоо үнэнч үхнэ

Энхийн хэлэлцээр хийдэг

Эргүү тэнэг нь би биш!

Эх орноосоо урвадаг

Элэггүй маанаг нь би би

Кан-си:

Ямарч аргагвйд хүрснээ

Яагаад ч ойлгохгвй байна уу, чи!

Ядуурлын туйлд хүрснээ

Юу гэх гээд байнаа, чи!

Холд минь согдоод ирэхийг чинь

Хоёр нүдээрээ харнаа би!

Ходлох тэнхээгвй болохыг чинь

Хэдхэн хоногоос харнаа

Галдан хаан:

Халхын хаадууд хамтарсан бол

Хана болон зогсох л байв

Халхын тусгаар тогтнолыг

Хамгаалж чадах нь үнэн байв

Би хэдий ганцаардсан ч

Билгийн нүд минь хараастай!

Бачит дайсны саварт

Баригданаа л гэж үгвй!

Кан-си: Их замын цэргүүд сонсоцгоо!

Эцсийн тулалдаанд урагшаа!

Чин улсын заналт дайсан

Цолийн дээрэмчин Галданг соноое!

Их буунууд галлаад!

Их замын цэргүүд давшаад! /Давшаад! Энэ үг хэдэнтээ давтагдана.

Галдан хаан: Дайчин эрс, баатрууд минь ээ!

Дайны шийдвэрлэх цаг ирлээ!

Улс эх орон минь ганцхан шvv дээ!

Ухрах газар байхгvйг санацгаа!

Дайраад! /энэ үг хэдэнтээ давтагдан түрэгдэнэ/

Тулаан эхлэж, мэс харшилдан, морьд үүрсэх, шархдагсдын дуу хадах, их бууны чимээ сонсогдсоор хошиг хаана.

ГАНЦААРДАЛ ХЭМЭЭХ ТАВДУГААР ҮЗЭГДЭЛ

Гадаа салхи исгэрч, шуурга дэгдэх чимээ гарна. Галдангийн гэр оргоо. Задгай гал түлнэ. Гэр салхинд уначихна уу гэлтэй оволзох аж. Гэрийн хойморт Галдан баавгайн арьсан дээр сууна. Данжила, ядарч зүдэрсэн царайтай, ноорхой хувцастай Ардар Хашка нар хааны дэргэд сууцгаана. Зарц эмгэн Түмэн-Солонго гал дээр хоол буцалгана

Ардар Хашка /Галданд хандан/:

Хаан таныгаа бараадаж

Хамаг насаа элээлээ!

Харсаар байтал ингээд

Харангадаж үхэх хэрэг үү!

Бошгот хаан таныгаа л

Бодож явсаар одий хүрлээ!

Болчимгвй энэ цаг вед

Буруулж таниасаа холдохоос!

Чимээгвй оргох сэтгэл алгаа!

Чимээлж тандаа дуулгалаа!

Оршоо, хаан минь, оршоо!

Оор аргагвй боллоо! – гээд моргоно.

Галдан хаан: Гар хол минь болж явсныг

Галдан хаан тань мэднээ!

Заавал надтай үлд гэж

Захирах эрх ч надад алгаа!

Та нарыгаа би тэтгэх

Тэнхээ чадалгүй боллоо!

Ардар Хашка минь, яв даа!

Аль дуртай зүгтээ яв даа!

Ардар Хашка бохийн хүндэтгэл үзүүлээд гарч одлоо. Галдан хааны сэтгэл ихэд шаналсан бололтой.

Галдан хаан: Зүүнгарын хаан байсан минь

Зүүд зэрэглээ биш байгаа даа!

Зоригт жанжин баатрууд минь

Зүг зүгтээ бутарлаа гэжvv!

Ядарч туйлдсан олон минь

Зам замаа харагдаа, хоорхий!

Амин зуулгаа тvшиж

Алс хэтийгээ дагагдаа, хоорхий!

Данжила: Хаантан минь, хаантан минь

Хатуухан тавилан таньд оногджээ!

Хаашаа ч зайлж, сэхэхийн аргагvй

Хувь заяаны дэнс оногджээ!

Халхын хаадууд Кан-Си-гээс

Хоол горьдон урвалаа!

Хүндхэн хувь заяаны

Хүлээсэнд нэгэнт оржээ, та!

Цаст уулын барс шиг

Цахилж явсан хаан та

Цагийн хатуу салхины

Цаламд нэгэнт оржээ, та!

Галдан хаан: Зүүн гарын хаан болж

Тодорч явсан цаг бий!

Сургууль, хийд байгуулж

Шашныг дэлгэрүүлсэн үе бий!

Дорнод Туркмен нутгийг

Дайлаар мордон эзлэж

Бошгот хаан цолыг

Далай ламаас хвртсээн би!

Буянт голын ховоонд

Ховд хотын тулгыг тулж

Буурал уулсынхаа дунд

Бууриа тэнд зассаан би!

Тариа ногоо ургуулахад

Түмнээ дайчилсан удаа ч бий!

Тэрслүү дайсны оодоос

Тэнгэрийн сум шиг ульсан ч бий!

Их цагаан хаан Алексейтэй

Эвийг хичээж ирсээн би!

Чин гүрний Кан-Си-тэй

Чоно лугаа тэмцэлдсээн би!

Данжила: Сайн сайхан явсан цаг

Санаанд л зовхон үлдлээ!

Самуун цагийн эрхээр

Сатаарлын аймшигт автлаа!

Ойр дотнын хувьд чинь

Оргон зайлж дүрвэлээ!

Цэвээн Равданд олзлогдон

Чин гүрэнтэй сүлбэлдлээ!

Галдан хаан: Гаднаа харагдах ишиггвй

Ганхийх нохойн гологгвй

Хvний дуу амьтны авиагвй

Хvйтэн дvнсгэр нутаг болов!- гээд Галдан нулимс дуслуулна.

Галдан цааш нь: Үнэний толоо тэмцэлд

Оштон яасан олон бэ?

Оорийн саднаас эхлээд

Урвагч яасан олон бэ?

Харийн дайсны оодоос

Хамсран босохгвй мортлоо

Хаан суудлын толоо

Хатгалдан тэмцэх нь утгагвй!

Кан-Си-д би баригдаж

Гарынх нь чилээг гаргахгвй!

Гавъяа, нүгэл хоёрыг минь

Ганцхан тvvх л ялгана!

Манж, хятадыг тvшвээс

Малаас ч дор болж хувирна!

Магадгвй, хойч ve минь

Манийгаа хараан зvхнэ!

Үхэн vхтлээ Галдан би

Үнэний толоо тэмцэлдэв!

Үгээгвй ядуу болсон ч

Омнод гүрнийг царайчлахгвй!

Кан-Си-д би баригдаж

Гарынх нь чилээг гаргахгвй!

Гавъяа, нүгэл хоёрыг минь

Ганцхан тvvх л ялгана! – сvvлчийн бадгийг арайхийн дуусган
гуйван дайвалзахад Данжила тvшиж авна. Үзэгдэл тогсоно.

ДЭМИЙРЭЛ ХЭМЭЭХ ЗУРГААДУГААР ҮЗЭГДЭЛ

Шоно дол. Галдангийн гэр оргоо. Тулганд галын цог сvvмэлзэнэ. Гэрийн хойморт Галдан унтаж байгаа харагдана. Зарц эмгэн Тvмэн-Солонго гэрийн зvvн хаяанд хэвтэж буй. Галдан хар даран зvvдэлж буй мэт болно. Ану хатангийн сvнс эргэж ирэн тэдний хооронд дараах яриа болно. Зарц эмгэн цочин сэрж, айн балмагдан тэдний яриаг сонсоно.

Ану хатны сvнс: Амраг нохор Галдан минь чи

Амар сайн байна уу, та?

Албат тvмэн чинь сайн уу?

Алдар хvнд чинь хэвээр vv?

Омог бардам бүргэд шиг

Шунгаж явсан чи минь!

Олны үйлсийн толоо

Оройлон дүүлсэн харцага минь!

Галдан хаан: Ану, Ану минь, чи сонсооч!

Алив наашаа, ойртоод ир!

Үнэнч чамаасаа хагацсанаас хойш

Үйлийн үрийг эдлэж явнаа!

Чин улстай дайтсаар

Цэргийн хвчин доройтлоо!

Ган зуданд нэрвэгдэж

Гол зогооход ч бэрх боллоо!

Ану хатны сүнс: Гутрах хэрэггүй, Галдан минь!

Гуних эрхгүй, Галдан минь!

Шударга үйлсийн толоо

Нударга зангидаж явсныг тань

Нийтийн үйлсийн толоо

Нэгэн биеэ зориулсныг тань

Эх орон тань мартаггүй!

Гэрэлт хошоо босгоно!

Үндэс угсаа нэгтэн тань

Үүрд дурсаж явах болно!

Галдан хаан: Зүрхний хайртай Ану минь, чи

Зориг зүрхийг минь чангаллаа!

Зорьсон хэргийнхээ толоо би

Зовж шаналахыг ч тоохгүй ээ!

Ану минь, чиний минь үг

Ахин намайгаа ховчиллоо!

Асгарах сумны оодоос

Аянгын гялбаа шиг цахилна би!

Ану хатны сүнс: Хайрт нохор таныгаа эргэж

Хамаг сэтгэл минь онгойлоо!

Бурханы зарлигийг дагая даа!

Буцах цаг минь нэгэнт боллоо! – гээд сүнс эргэхэд

Галдан хаан /араас нь/: Байз, Ану минь, түр хвлээ!

Би ч араас чинь очноо!

Тавилан заяаныхаа тооргоор

Диваажинд ч хамт жарганаа! – хэмээн дуулна. Галдангийн сэтгэл ихэд хоорсон байдалтай харагдана. Зарц Түмэн Солонго айн чичирч сууснаа:

Зарц Түмэн Солонго: Хаантан минь, та сая хэнтэй

Харгалдан ярилцаад байв!

Насан хутгыг олсон нэгэн үү?

Надад л огтоос харагдсангүй

Галдан хаан: Ану хатны минь сүнс эргэж

Арга тасарсан намайг ховчлоод буцав.

Алагхан хорвоогийн жамыг дагаж

Араас нь ч би очмоор байна

Зарц Түмэн Солонго: Унтаж амардаа, хаантан минь

Үүр цайх ч дохож байна.

Шоножин та дэмий ярилаа!

Шүлэг нойрондоо умба даа!

Галдан хаан унтахаар дахин хэвтэх авч нойр нь эс хврэх ажээ. Тэрээр хэдэнтээ эргэж хорвосноо:

Нойр хврэх янзгвй нь ээ!

Нэгэн үлгэр яриач дээ!

Үлгэрийн сайхныг мэдэрвээс

Үүрээр дугхийж ч юун магад!

Зарц Түмэн Солонго: Ээ хаантан минь, хаантан минь!

Эгч нь хамаг үлгэрээ дууссаан!

Яая даа байз, хаантан минь!

Явган мэргэний домгийг ярихуу даа!

Галдан хаан: Тэг дээ, тэг эгч минь

Тэр домгоо хвүрнээч!

Зарц Түмэн Солонго: Нар сарыг халхалсан

Нэгэн том шувуу

Бээжин хотод буй болж

Бум олныг бужигнуулжээ.

Энэ шувууг дийлэх хвчтэн

Тэр хавьдаа олдсонгвй гэнэ.

Тив дэлхийгээр хайгаад ч

Тусыг эс олж гэнээ.

Ойрадын Явган мэргэн л

Оновчтой сайн харвадаг

Түүнээс оор хэн боловч

Тэр шувууг дийлэхгүй гэж

Манжийн эзэн хаан

Мэргэдээс сонссон юмсанжээ.

Яхав, тэгээд л манжийн хаан

Явган Мэргэнийг урьж гэнэ.

Явган мэргэн ч ирж гэнэ.

Тэр шувууг ч дарж гэнэ.

Явган Мэргэнээс эмээж гэнэ.

Яаж ч мэднэ гэж айж гэнэ.

Хоолонд нь хор хийж

Хоорхий мэргэнийг хоноож гэнэ. – хэмээн дуулахад

Галдан уурсан: За, за одоо боль!

Залхаж гүйцлээ би!

Тусыг усаар хариулдаг

Тэрслvv манж нарыг уу!?- гэж хараал тавина. Хошиг хаана.

ТОГСГОЛ

Гадаа задгай тvлсэн галын нурам уугина. Данжила тэргvвтэй хэдэн ядарсан царайтай хvмvvc галын дэргэд уруу царайлан тойрон зогсоно. Нэгэн лам уншлага уншин суух авай. Цаана нь Галдангийн хээрийн оргоо харагдана. Данжила илгэн хvvdий, галын хайч барьсан байна. Албатууд, сайд, жанжнууд хэсэг хэсгээр ирсээр тайз дvврнэ.

Данжила: Газар тэнгэр хомрох шиг

Гамшиг бидэнд учирлаа!

Галдан хаан жанч хальж

Гарз хохирол амслаа!

Эрдэм чадалт Бошгот минь!

Эрэмгий дайчин хаан минь!

Эх орондоо монхжээрэй!

Эргэж бидэндээ тороорэй!

Алтайн уулс минь нурах шиг

Аймшиг бидэнд учирлаа!

Алтайн уулс сүнсийг тань хадгална!

Ард олон сэтгэлийг тань хадгална!

Зүүнгарын хаан Галдан та,

Зоригт бүргэд байсан билээ!

Зовол жаргалт ертонцийн жамаар

Жанч халилаа, хаан минь!

Манж нар Галдангийн цогцсыг

Мошгин хайн олж аваад

Атаа хорслоо тайлах гэж

Аль муухайгаар бузарлах тул

Галдан хааныхаа ариун цогцсыг

Галынхаа долонд тушаалаа бид!

Аюулт дайсанд цогцсыг чинь огохгвй!

Алтайнхаа ууланд чандрыг нь хийсгээ!

Гал оодоо! – гээд хайчаар ясыг тvvн авч илгэн хvvдийд хийнэ.

Данжила: Галдан хааны жанч хальсан мэдээг

Кан-Си - д дуулгах хэрэгтэй байна!

Цэцэр-зайсан, арван хvн аваад

Чин гvрнийг яаралтай зорь!

Цэцэр-зайсан: Ёсоор болгоёо, Данжила минь!

Явалгvй яахав, энэ цаг вед!

Омнод гvрнийг зорьёдоо би!

Оорийн биеэр Кан-Си-д айлтгая!

Хоор дуу: Ойрадын тvмэн олны маань

Од болсон Бошгот хаан минь!

Орчих цагийн эрхийг дагаж

Од болон харвалаа, та минь!

Хаан таныхаа сэдсэн бүхнийг

Хамтран дээдэлж явцгаая!

Хайрлан моргодог Алтай нутгаа

Хамгаалан тэмцэж явцгаая!

Эх орон минь ганцхан шvv дээ!

Эрээд хаанаас ч олдохгvй шvv дээ!

Эрх чолоо, тусгаар тогтнолоо

Эрхэмлэн дээдлэж амьдарцгаая!!

Гарчиг

ЭХЛЭЛ

ЗОВШИЛ ХЭМЭЭХ НЭГДУГААР ҮЗЭГДЭЛ

ТЭРСЛЭЛ ХЭМЭЭХ ХОЁРДУГААР ДУГААР ҮЗЭГДЭЛ

АВЛАЛ ХЭМЭЭХ ГУРАВДУГААР ҮЗЭГДЭЛ

АРСАЛДАЛ ХЭМЭЭХ ДОРОВДҮГЭЭР ҮЗЭГДЭЛ

ГАНЦААРДАЛ ХЭМЭЭХ ТАВДУГААР ҮЗЭГДЭЛ

ДЭМИЙРЭЛ ХЭМЭЭХ ЗУРГААДУГААР ҮЗЭГДЭЛ

ТОГСГОЛ

Ховд хот. 2004 он